



## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 183/ШЗ2019/05036

Улаанбаатар хот

Шүүхээс гарах шийдвэрийн  
биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай

Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Энхцэцэг би, Таван богд трейд ХХК-ийн нэхэмжлэлтэй Атар өргөө ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлд холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан хүсэлтийг хүлээн авч хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүхэд гаргасан хүсэлтдээ: Нэхэмжлэгч Таван богд трейд ХХК нь Атар өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигч бөгөөд тус дүүргийн шүүхэд Атар өргөө ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/-ийн 2019 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн хурлын Атар өргөө ХК-ийн 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр зарлан хуралдуулах тухай 01/02 тоот тогтоол хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох тухай” нэхэмжлэлийг шүүхэд гаргасан. Атар өргөө ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарах хүртэлх хугацаанд Атар өргөө ХК-ийн 2019 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахыг түдгэлзүүлэх хүсэлтийг гаргаж байна. Атар өргөө ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01/02 тоот тогтоолоор тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр хуралдуулахаар зарлажээ. Тус компани ТУЗ нь Атар Өргөө ХК-ийн хувьд сүүлийн гурван жил дараалан 2017, 2018, 2019 онуудад Атар Өргөө ХК нь хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах харилцааг зохицуулдаг Монгол улсын бүх хууль, тогтоомжийг мөрдөхгүй зөрчиж байна. 2018 оны хувьцаа эзэмшигчдийн хурлыг Таван богд трейд ХХК, Улаанбаатар гурил ХХК-ийн нэхэмжлэлээр тус дүүргийн шүүхийн 2018 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 183/ШЗ2018/05104 дугаар шүүгчийн захирамжаар Атар өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарласан тогтоолын биелэлтийг түдгэлзүүлсэн. Иймээс хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдаагүй учир Атар өргөө ХК-ийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулахаас бусад Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно гэж заасны дагуу ТУЗ-ын бүрэн эрхгүй болсон. Энэхүү ТУЗ нь Компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндөж бусад хувьцаа эзэмшигч нарын ТУЗ-д нэр дэвшүүлэх боломжийг хаах замаар 2019 оны ТУЗ-ыг сонгох болон 2019 оны ТУЗ-ын дүгнэлтийг гаргасныг хэлэлцүүлэхээр, Компанийн төсвийг батлах, Ногдол ашиг хуваарилах талаарх оруулж байгаа нь хууль бус болсон. Тодруулбал: энэхүү асуудлыг тухайн ТУЗ нь хэлэлцэх эрхгүй. Хэдийгэр компанийн үйл ажиллагааны хувьд ТУЗ-ыг сонгох асуудал чухлаар тавигдаж байгаа ч хувьцаа эзэмшигчдийн сонгох эрхийг хууль бусаар хязгаарлан хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаж, ТУЗ-д өөрийн гэр бүлийн гишүүдээ улируулан сонгуулахаар дахин нэр дэвшүүлэх ёсгүй. Мөн компанийн тухай хуульд заасан

0016044

хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулахаар шийдвэрлээд зогсохгүй 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын дүгнэлт гаргасан, ногдол ашиг хуваарилах эсэх асуудлаар ТУЗ-ын шийдвэр түүний үндэслэлийг танилцуулах асуудлыг хэлэлцүүлэхээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулсан байгаа нь ТУЗ эдгээр асуудлыг хэлэлцэж шийдсэн нь хууль бус болсныг харуулж байна. Иймээс ТУЗ-ын хувьцаа эзэмшигчдийн хурлаа хууль бусаар зарласан байх тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.5-т заасны дагуу 2019 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 01/02 тоот тогтоолын биелэлтийг түдгэлзүүлэхийг хариуцагч Атар Өргөө ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захиралд даалгаж өгнө үү” гэжээ.

Шүүх нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлтийг судлаад

ҮНДЭСЛЭХ нь:

Шүүхээс гарах шийдвэр баталгаатай биелэгдэх нөхцөл байдлыг урьдчилан бэлтгэхийн тулд нэхэмжлэгч шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авахуулахаар шүүхэд хүсэлт гаргаж болох ба Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.5 дахь хэсэгт тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгах арга хэмжээ авах тухай зохицуулсан байна.

Нэхэмжлэгч шүүхэд Атар өргөө ХК-н төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн Атар өргөө ХК-ийн 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр зарлан хуралдуулах тухай 01/02 тоот тогтоол хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох тухай шаардлага гаргасан байх тул тухайн тогтоолын биелэлтийг түдгэлзүүлэх тухай хүсэлт нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.5-д заасанд хамаарах буюу нэхэмжлэлийн шаардлагатай хамааралтай гэж үзэхээр байна.

Иймд нэхэмжлэгчийн хүсэлтийг хангаж, Атар өргөө ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 01/02 тоот тогтоолын биелэлтийг түдгэлзүүлэхийг Атар өргөө ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлд даалгахаар шийдвэрлэв.

Түүнчлэн, нэхэмжлэгч хүсэлтээ Атар өргөө ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захиралд даалгах гэж тодорхойлсон боловч шүүхээс гаргах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ зөвхөн хариуцагчид хамаарах тул гүйцэтгэх захиралд даалгах үндэслэлгүйг тайлбарлах нь зүйтэй.

Шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасан арга хэмжээ авсны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр хариуцагч нэхэмжлэл гаргаж болохыг дурдаж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.1.5, 123 дугаар зүйлийн 123.1-д заасныг удирдлага болгон

ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Таван богд трейд ХХК-ийн нэхэмжлэлтэй Атар өргөө ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлд холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлтийг хангаж, Атар өргөө ХК төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 01/02 тоот тогтоолын биелэлтийг

түдгэлзүүлэхийг хариуцагч Атар Өргөө ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

2. Шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасан арга хэмжээ авсны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр хариуцагч нэхэмжлэл гаргаж болохыг дурдсугай.

3. Энэхүү шүүгчийн захирамжид гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шүүхэд гомдол гаргах эрхтэйг дурдсугай.

ШҮҮГЧ



Д.ЭНХЦЭЦЭГ

